



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ**

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,  
Утас: 9226-3051, Факс: (976) 7004-3479  
E-mail: info@energy.gov.mn

2019. 11. 18 № 8/4194

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Шагналд нэр дэвшүүлэх  
материал ирүүлэх тухай**

Эрчим хүчний салбарын 2019 оны шилдгийг тодруулах арга хэмжээний хүрээнд Эрчим хүчний салбарын шилдэг байгууллага, ерөнхий инженер, инженер, мастер, ажилтан, бүтээн байгуулалтын ажлыг шалгаруулах журмын дагуу өөрийн байгууллагаас дээрх ангилалд нэр дэвшүүлэх санал, холбогдох материалыг маягтын дагуу шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой гаргаж 2019 оны 12 дугаар сарын 05-ны дотор ирүүлнэ үү.

Жич: Тус журмын 1, 2, 3, 4 дүгээр хавсралтуудыг файл хэлбэрээр гаргаж тус яамны Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн П.Даваанямд ирүүлнэ. Цахим хаяг: [davaanyam@energy.gov.mn](mailto:davaanyam@energy.gov.mn)

Эрчим хүчний салбарын шилдэг байгууллага, ерөнхий инженер, инженер, мастер, ажилтан, бүтээн байгуулалтын ажлыг шалгаруулах журмыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 8 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

М.БАТГЭРЭЛ



008003354

БАТЛАВ: ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ М. БАТГЭРЭЛ

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА,  
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР, ИНЖЕНЕР, МАСТЕР, АЖИЛТАН, БҮТЭЭН  
БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫГ ШАЛГАРУУЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.1. Эрчим хүчний салбарын шилдэг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагууд, инженер, техникийн ажилтнуудын хөдөлмөр, бүтээлийг үнэлэх, тэдгээрийг алдаршуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр.Нэр дэвшүүлэх

2.1. Эрчим хүчний салбарын үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагууд нь дараах ангилалд нэр дэвшүүлнэ.

2.1.1. Эрчим хүчний салбарын төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагууд нь өөрийн байгууллагын тухайн жилийн үйлдвэрлэл, эдийн засгийн үзүүлэлт, техникийн бодлого, технологийн сахилга, хамт олны ажлын амжилтыг үндэслэн "ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2019 ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА"-д нэр дэвшүүлнэ.

2.1.2 Эрчим хүчний салбарын хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагууд нь өөрийн байгууллагын тухайн жилийн гэрээгээр гүйцэтгэсэн засвар, барилга угсралтын ажлын цар хүрээ, биелэлт, захиалагчаас өгсөн үнэлгээ, шинэ техник, технологи нэвтрүүлсэн байдал зэргийг үндэслэн "ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2019 ОНЫ ШИЛДЭГ ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГА"-д нэр дэвшүүлнэ.

2.1.3. Техникийн бодлого, технологийн сахилга, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулж, мэргэжлийн ур чадвараа дайчлан ажиллаж, өөрийн компанийг салбарын хэмжээнд тодорхой амжилтад хүргэсэн ерөнхий инженерийг "ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2019 ОНЫ ШИЛДЭГ ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР"

2.1.4. Эрчим хүчний үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагууд нь хамт олноо хошуучлан өндөр ур чадвар гарган ажилласан ажилтнуудыг дараах ангилалд нэр дэвшүүлнэ. **Үүнд:**

- Эрчим хүчний салбарын "2019 ОНЫ ШИЛДЭГ ИНЖЕНЕР"
- Эрчим хүчний салбарын "2019 ОНЫ ШИЛДЭГ МАСТЕР"
- Эрчим хүчний салбарын "2019 ОНЫ ШИЛДЭГ АЖИЛТАН"

Тайлбар: "2019 ОНЫ ШИЛДЭГ АЖИЛТАН"-д тухайн байгууллагын инженер техникийн ажилтан, мастеруудаас бусад бага болон дунд тушаалын ажилчид, албан хаагчид хамаарна.

2.1.5 Эрчим хүчний салбарын үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагууд нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр тухайн жилд хэрэглэгчдийг тасралтгүй найдвартай эрчим хүчээр хангах ажилд идэвхи санаачилга гарган ажиллаж, өөрийн хөрөнгөөр үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж, шинэ дэвшилтэт

технологийг нэвтрүүлэн салбарын хөгжилд тодорхой нөлөөлөхүйц хэмжээний хувь нэмрээ оруулсан томоохон ажлыг “2019 ОНЫ ШИЛДЭГ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ”-д нэр дэвшүүлнэ.

### Гурав.Шалгаруулах үзүүлэлт

3.1.Эрчим хүчний салбарын оны шилдэг ерөнхий инженер, инженер, мастер, ажилтнуудыг шалгаруулахдаа дараах үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэнэ.

/Хүснэгт 1/

Д/д	Төрийн болон орон нутгийн өмчит, хувийн хэвшлийн эрчим хүч үйлдвэрлэгч компани		Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага /БУА/	
	Үзүүлэлт	Эзлэх хувь	Үзүүлэлт	Эзлэх хувь
1.	а/ өөрийн харьяаллын тоног төхөөрөмжийн жигд ажиллагаа хангагдсан эсэх, б/ шинээр техник, технологи нэвтрүүлсэн байдал, хийсэн бүтээлч ажлууд	30	а/Засвар, барилга угсралтын ажлын гэрээний биелэлт, б/шинэ техник, технологи нэвтрүүлсэн байдал.	30
2.	а/ тухайн жилд төлөвлөгдсөн засвар, үйлчилгээг бүрэн хийсэн эсэх	20	а/шинэ бүтээл, ашигтай загвар, түүний үр дүнгээр хэмнэсэн хөрөнгө, үйл ажиллагаанд гарсан дэвшил	15
3.	а/хувь хүний чадавхи, санаачилга, хариуцсан хэсгийн чадварыг, байгууллага үнэлсэн үнэлгээ. б/Хөдөлмөр зохион байгуулалт, хариуцлага /мастеруудыг дүгнэх үзүүлэлт/	20	а/Засварын ажлын талаарх захиалагчийн үнэлгээ б/Дагалдуулан сургаж мэргэшүүлсэн ажилчид, тэдгээрийн чадавхи дээшилсэн байдал /мастеруудыг дүгнэх үзүүлэлт/	20
4.	а/ААД, ТАД, ГАУСД-ийг мөрдөж ажилласан байдал. б/Аваари, саатал, ослын үнэлгээ	15	а/ААД, ТАД, ГАУСД-ийг мөрдөж ажилласан байдал б/Хөдөлмөр зохион байгуулалт, хариуцлага	20
5.	а/ Хариуцсан нэгж, ажлын байрны эмх цэгц, хөдөлмөрийн сахилга, хуулийн мөрдөлт, төлөвшилт б/ Хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргээ ур чадвартай гүйцэтгэж өндөр үнэлгээ авсан /ажилтнуудыг дүгнэх үзүүлэлт/	15	а/Засвар, барилга угсралтын ажлыг улсын болон техникийн комиссоор хүлээлгэн өгөхөд бүрдүүлсэн материалууд, тэдгээрийн эмх цэгц, бүрэн бүтэн байдал	15

3.2. Эрчим хүчний үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагуудын тухайн жилийн ажлын үр дүнг энэхүү журмын хавсралтаар батлагдсан үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн оны шилдэг байгууллагыг шалгаруулна. /Хүснэгт 2/

3.3. Хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангах үйлсэд идэвх санаачилга гарган ажиллаж, өөрийн хөрөнгөөр үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулсан томоохон бүтээн байгуулалтын ажлыг шалгаруулна. /Тухайн жилд онцгой гэж үзэх материал ирээгүй бол энэ номинацыг шалгаруулахгүй байж болно.

д/д	Дүгнэх үзүүлэлт	Төрийн болон орон нутгийн өмчит, хувийн хэвшлийн эрчим хүч үйлдвэрлэгч компани	Эзлэх хувь	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага /БУА/	Эзлэх хувь
		Үзүүлэлт		Үзүүлэлт	
1.	Үйлдвэрлэлтийн үзүүлэлт	а/ Цахилгаан эрчим хүчний түгээлт б/ Дулааны эрчим хүчний түгээлт в/Дотоод хэрэгцээнд зарцуулсан эрчим хүч г/ Дамжуулалт түгээлтийн алдагдал	20	а/ Засвар, барилга угсралтын ажлын гэрээний биелэлт, чанар б/ Их засвар, барилга байгууламжийн жилийн ажлын гүйцэтгэл	25
2.	Эдийн засгийн үзүүлэлт	а/ Нийт зардал б/ Тогтмол зардал в/ Ашиг /алдагдал/ г/ Богино хугацаат авлага /өглөг/ д/ Жишмэл түлшний хувийн зарцуулалт е/ Сэлбэг материалын үлдэгдлийн бууралт ё/ Тухайн оны борлуулалт, орлого төвлөрүүлэлт	20	а/ Их засвар, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг захиалагчаас үнэлсэн үнэлгээ б/ Нормчлолын сан, тусгай зөвшөөрлийн хураамж төлсөн эсэх	25
3.	Технологийн сахилга	а/ Үйлдвэрлэлийн осол аваари, саатал б/ Ашиглалтын жигд ажиллагаа, горимын зөрчил в/ Тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга, үзлэг шалгалтын графикийн биелэлт	15	а/ Засвар, барилга угсралтын ажлын технологийн мөрдөлт б/ Засвар, барилга угсралтын ажилд хэрэглэсэн материал сэлбэгийн үйлдвэрийн паспорт, гарал үүсэл, чанарын баталгаажуулалт в/ Үйлдвэрлэлийн осол г/ Засвар барилга угсралтын ажлыг техникийн нөхцөл, зургийн даалгаврын дагуу хийсэн эсэх, түүний биелэлт д/ ТАД, ААД-ийн биелэлт	20
4.	Техникийн бодлого	а/ Өвлийн бэлтгэл ажлын биелэлт б/ Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт	20	а/ Компанийн материаллаг баазын үнэлгээ б/ Компанийн ажиллагсдын тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эсэх в/ Ажиллах хүчний чадавх	20
5.	Хамт олны оюуны чадавхын үнэлэмж	а/ Техник технологийн шинэчлэлт /иноваци/	10	а/ Техник технологийн шинэчлэлт	10
6.	Үзлэгийн дүн	а/ Хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт б/ ХХАА, ГАУС ажлын биелэлт в/ Ажлын байрны эмх цэгц г/ Техникийн бичиг баримтын хөтлөлт д/ Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлууд	15		

## Дөрөв. Шалгаруулах журам

4.1. Комисс нь дараах хуваарийн дагуу шалгаруулалтад оролцохоор материалаа ирүүлсэн байгууллагуудын хүсэлтийг хүлээн авч, судлан үзэж, энэхүү журамд заагдсан үзүүлэлтүүдийн дагуу үнэлж дүгнэнэ.

4.1.1. Оны шилдэг байгууллага, бүтээн байгуулалт, шилдэг ерөнхий инженер, шилдэг инженер, шилдэг мастер, шилдэг ажилтанд өрсөлдөх оролцогчдын материалыг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор комисст ирүүлнэ.

4.2. Комисс нь материал хүлээн авах хугацаа дууссан өдөр шалгаруулалтад оролцохоор хүсэлтээ ирүүлсэн оролцогчдын жагсаалтыг гаргаж, ажлын 5 хоногт багтаан үнэлж дүгнэнэ.

4.4. Комисс нь шалгаруулалтын дүнг Эрчим хүчний сайдад танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулан албажуулна.

4.5. Комисс шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн материал нь хангалтгүй, шаардлага хангахгүй, эсвэл шалгаруулалтад оролцохоор хүсэлт ирээгүй тохиолдолд тухайн ангилалд тухайн оны шилдгийг шалгаруулахгүй байж болно.

### Тав. Шагнал гардуулах ажиллагаа

5.1. Оны шилдгээр шалгарсан байгууллага, шилдэг бүтээн байгуулалт, ерөнхий инженер, инженер, мастер, ажилтнуудад өргөмжлөл, цом, мөнгөн шагнал /хоёр сая төгрөг/-аар шагнана.

5.2. Дээрх шагналуудыг тухайн жилийн эцэст Эрчим хүчний яамны хүндэтгэл, ёслолын арга хэмжээний үеэр гардуулна.

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Эрчим хүчний салбарын  
шилдэг шалгаруулах журмын  
дүгээр хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2019 ОНЫ “ШИЛДЭГ ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР”, “ШИЛДЭГ  
ИНЖЕНЕР”, “ШИЛДЭГ МАСТЕР”, “ШИЛДЭГ АЖИЛТАН”-Т НЭР ДЭВШИГЧИДИЙГ  
ҮНЭЛЖ, ДҮГНЭХ ХУУДАС

№	Үзүүлэлт	Тайлбар
1	Овог нэр	
2	Одоо эрхэлж буй албан тушаал	
3	Компанийн нэр	
4	Мэргэжил	
5	Эрчим хүчний салбарт ажилласан жил	
6	Авсан шагнал урамшуулал	
7	Компанийн техник, эдийн, засгийн үзүүлэлт, найдвартай байдлыг хангахад нэвтрүүлсэн санал, санаачилга (хүн тус бүрээр)	

**Тайлбар:** ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2019 ОНЫ “ШИЛДЭГ ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР”, “ШИЛДЭГ ИНЖЕНЕР”, “ШИЛДЭГ МАСТЕР”, “ШИЛДЭГ АЖИЛТАН”-д  
нэр дэвшигчидийн хуудсыг бөглөхдөө тухайн журмын 3.1 дэх заалтын дагуу товч  
бөгөөд тодорхой нүүр хуудсыг бөглөж ирүүлнэ. (Мөн тухайн нэр дэвшигчийн  
дэлгэрэнгүй материалыг хавсаргаж ирүүлнэ.)

**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2019 ОНЫ ШИЛДЭГ ТӨРИЙН  
БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИ**

д/д	Дүгнэх үзүүлэлт	Үзүүлэлт	2019 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл /ХБГ/
1.	Үйлдвэрлэлтийн үзүүлэлт	а/ Цахилгаан эрчим хүчний түгээлт б/ Дулааны эрчим хүчний түгээлт в/Дотоод хэрэгцээнд зарцуулсан эрчим хүч г/ Дамжуулалт түгээлтийн алдагдал		
2.	Эдийн засгийн үзүүлэлт	а/ Нийт зардал б/ Тогтмол зардал в/ Ашиг /алдагдал/ г/ Богино хугацаат авлага /өглөг/ д/ Жишмэл түлшний хувийн зарцуулалт е/ Сэлбэг материалын үлдэгдлийн бууралт ё/ Тухайн оны борлуулалт, орлого төвлөрүүлэлт		
3.	Технологийн сахилга	а/ Үйлдвэрлэлийн осол аваари, саатал б/ Ашиглалтын жигд ажиллагаа, горимын зөрчил в/ Тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга, үзлэг шалгалтын графикийн биелэлт		
4.	Техникийн бодлого	а/ Өвлийн бэлтгэл ажлын биелэлт б/ Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт		
5.	Хамт олны оюуны чадавхын үнэлэмж	а/ Техник технологийн шинэчлэлт /иновац/		
6.	Үзлэгийн дүн	а/ Хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт б/ ХХАА, ГАУС ажлын биелэлт в/ Ажлын байрны эмх цэгц г/ Техникийн бичиг баримтын хөтлөлт д/ Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлууд		

**Тайлбар:** Эрчим хүчний салбарын 2019 оны шилдэг Төрийн болон орон нутгийн өмчит компанийн материалд тухайн нүүр хуудсыг бөглөх ба дэлгэрэнгүй материалуудыг хавсаргаж ирүүлнэ.

**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2019 ОНЫ ШИЛДЭГ ХУВИЙН  
ХЭВШЛИЙН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА**  
/Эрчим хүч үйлдвэрлэгч/

д/д	Дүгнэх үзүүлэлт	Үзүүлэлт	2019 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл /ХБГ/
1.	Үйлдвэрлэлтийн үзүүлэлт	а/ Цахилгаан эрчим хүчний түгээлт б/ Дулааны эрчим хүчний түгээлт в/Дотоод хэрэгцээнд зарцуулсан эрчим хүч г/ Дамжуулалт түгээлтийн алдагдал		
2.	Эдийн засгийн үзүүлэлт	а/ Нийт зардал б/ Тогтмол зардал в/ Ашиг /алдагдал/ г/ Богино хугацаат авлага /өглөг/ д/ Жишмэл түлшний хувийн зарцуулалт е/ Сэлбэг материалын үлдэгдлийн бууралт ё/ Тухайн оны борлуулалт, орлого төвлөрүүлэлт ж/ Нормчлолын сан, тусгай зөвшөөрлийн хураамж төлсөн эсэх		
3.	Технологийн сахилга	а/ Үйлдвэрлэлийн осол аваари, саатал б/ Ашиглалтын жигд ажиллагаа, горимын зөрчил в/ Тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга, үзлэг шалгалтын графикийн биелэлт		
4.	Техникийн бодлого	а/ Өвлийн бэлтгэл ажлын биелэлт б/ Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт		
5.	Хамт олны оюуны чадавхын үнэлэмж	а/ Техник технологийн шинэчлэлт /иноваци/		
6.	Үзлэгийн дүн	а/ Хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт б/ ХХАА, ГАУС ажлын биелэлт в/ Ажлын байрны эмх цэгц г/ Техникийн бичиг баримтын хөтлөлт д/ Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлууд		

**Тайлбар:** Эрчим хүчний салбарын 2019 оны шилдэг Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын материалд тухайн нүүр хуудсыг бөглөх ба дэлгэрэнгүй материалуудыг хавсаргаж ирүүлнэ.

Эрчим хүчний салбарын  
шилдэг шалгаруулах журмын  
дүгээр хавсралт

**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2019 ОНЫ ШИЛДЭГ ХУВИЙН  
ХЭВШЛИЙН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА**  
/Барилга угсралтын ажил гүйцэтгэгч/

д/д	Дүгнэх үзүүлэлт	Үзүүлэлт	2019 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл /ХБГ/
1.	Үйлдвэрлэлтийн үзүүлэлт	а/ Засвар, барилга угсралтын ажлын гэрээний биелэлт, чанар б/ Их засвар, барилга байгууламжийн жилийн ажлын гүйцэтгэл		
2.	Эдийн засгийн үзүүлэлт	а/ Их засвар, барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг захиалагчаас үнэлсэн үнэлгээ б/ Нормчлолын сан, тусгай зөвшөөрлийн хураамж төлсөн эсэх		
3.	Технологийн сахилга	а/ Засвар, барилга угсралтын ажлын технологийн мөрдөлт б/ Засвар, барилга угсралтын ажилд хэрэглэсэн материал сэлбэгийн үйлдвэрийн паспорт, гарал үүсэл, чанарын баталгаажуулалт в/ Үйлдвэрлэлийн осол г/ Засвар барилга угсралтын ажлыг техникийн нөхцөл, зургийн даалгаврын дагуу хийсэн эсэх, түүний биелэлт д/ ТАД, ААД-ийн биелэлт		
4.	Техникийн бодлого	а/ Компанийн материаллаг баазын үнэлгээ б/ Компанийн ажиллагсдын тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эсэх в/ Ажиллах хүчний чадавх		
5.	Хамт олны оюуны чадавхын үнэлэмж	а/ Техник технологийн шинэчлэлт		
6.	Үзлэгийн дүн	а/ ХХАА, ГАУС ажлын биелэлт б/ Ажлын байрны эмх цэгц в/ Техникийн бичиг баримт бүрдүүлэлт г/ Байгаль хамгаалах чиглэлээр хийсэн ажлууд		

**Тайлбар:** Эрчим хүчний салбарын 2019 оны шилдэг Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын материалд тухайн нүүр хуудсыг бөглөх ба дэлгэрэнгүй материалуудыг хавсаргаж ирүүлнэ.